



БАЯНХОНГОР АЙМГИЙН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан:procurement.bayankhongor@audit.gov.mn

2025-07-22. № 1/421.

танай _____ -ны № _____ -т

Г Хандивын тайлангийн дүгнэлт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Монгол ардын намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай Хуулиар тодорхойлсон Төрийн Аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох Монгол ардын нам нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана. хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайландаа тусгагдаагүй хандивыг хянан баталгаажулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Монгол ардын намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих

6425020531

нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Монгол ардын нам нь тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хандивын аваагүй талаар тайлан ирүүлсэн нь баримтаар нотлогдож байна.

